Хураангуй. Дэлхийд хөгчүү (*Tringa*) төрлийн нийт 13 зүйл, манай оронд 8 зүйл шувуу бүртгэгдсэн ба тэдгээрийн хавар, намрын нүүдлийн оргил үе тодорхойгүй, нүүдлийн замналын талаарх баримт хомс байна. Бид энэ өгүүлэлдээ Чух нуурт 2019-2021 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээ орууллаа. Чух нуурт гурван жилд хөгчүүний төрлийн долоон зүйлийн 277 бодгаль шувууг барьж, бөгжилсөн. Чух нуураар дайран өнгөрч буй шувуудын хаврын нүүдлийн идэвхжил 2019 онд 5-р сарын 26-30-ны хооронд тохиосон бол 2020 онд 5-р сарын 14-20-ний хооронд байв. Намрын нүүдлийн идэвхжил гурван жилийн хугацаанд 8-р сарын 01-ээс 4-ний хооронд тохиосон харьцангуй тогтвортой байна. Бид дөрвөн зүйл хөгчүүний долоон бодгальд сансрын дамжуулагч зүүж тэдгээрийн нүүдлийн замнал, үрждэг, өвөлждөг мөн нүүдлийн үедээ бууж амардаг газруудыг тодорхойллоо. Хар хөгчүүний бие гүйцсэн бодгаль Чух нуураас 2027.3 км зам туулан Хятадын Хенан (Henan) мужид хүрч өвөлжсөн бол Үхэр хөгчүү Чух нуураас 2444 км зам туулж Хятадын Хунаньд (Hunan) хүрсэн. Буурал хөгчүүний бие гүйцсэн бодгаль дамжуулагч зүүснээс найман өдрийн дараа Оросын Арахлей (Arakhley) нууранд бүртгэгдсэн. Үүнээс хойш 54 өдрийн дараа Хятадын Жоу Зи (Zhouzi) мужид бүртгэгдсэн. Улаанхөлт хөгчүүний бие гүйцсэн бодгаль намрын нүүдэлдээ 5690 км, хаврын нүүдэлдээ 6000 км замыг туулсан.

Түлхүүр үгс: нүүдлийн оргил үе, сансрын дамжуулагч, Монгол дагуур

Хүлээн авсан 2023.11.24; хянан тохиолдуулсан 2024.01.22; зөвшөөрсөн 2024.02.15

© 2023 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

Оршил

Дэлхийд шувуудын үржлийн болон өвөлждөг бүс нутгийг холбосон нийт найман нүүдлийн зам байдгаас хамгийн том нь манай орны зүүн хэсгээр дайран өнгөрдөг Зүүн-Ази Австрали-Азийн Нүүдлийн Зам (ЗААНЗ) бөгөөд энэ замаар 492 зүйлийн 50 сая орчим шувууд нүүдэллэдэг [1]. Манай орноор ЗААНЗ болон Төв ази, Зүүн Ази Зүүн Африкийн нүүдлийн зам дайран өнгөрдөг. ЗААНЗ-аар дайран өнгөрдөг нэг гол бүс нутаг нь Монгол дагуурын дархан цаазат газрын орчны бүсэд байх Чух нуур юм [4]. Энэ нуураар олон зүйл эргийн шувуу болон усны шувуу нүүдлийн үедээ дайран өнгөрдөг, үрждэг [2]. Дэлхийд хөгчүү (*Tringa Linnaeus, 1758*) төрлийн нийт 13 зүйл шувууд бүртгэгдсэн [3] байдгаас

манай оронд найман зүйл нь тэмдэглэгджээ [5]. Энэ төрлийн шувууд нь Хиазатан (*Charadriiformes*) багийн Хомноотон (*Scolopacidae*) овогт хамаарагддаг ба нуур, цөөрмийн хөвөө, голын эрэг орчмоор амьдардаг шувууд юм. Эдгээрээс Сүүлцагаан хөгчүү (*Tringa ochropus*), Шугуйн хөгчүү (*Tringa glareola*), Улаанхөлт хөгчүүний (*Tringa totanus*) судалгаа бусад орнуудад харьцангуй их хийгдсэн боловч [13] нүүдлийн замнал, шилжилт хөдөлгөөний бие даасан судалгаа хомс байна. Судлаач Болд ба Эрэгдэндавга (1970), Болд(1973), Цэвээнмядаг (1979), Цэвээнмядаг нар(2000), Болдбаатар (2006, 2008) нарын судалгааны явцад дээрх зүйл шувууд нь гол, нуурын эрэг, шавар намагтай газруудад бүртгэгдсээр иржээ. Бид судалгааны ажлын хүрээнд Чух нуураар дайран

өнгөрөх хөгчүү (*Tringa Linnaeus, 1758*) төрлийн шувуудын нүүдлийн идэвхжил, нүүдлийн замнал, шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох зорилго тавин дараах зорилгын дагуу ажиллаа. Үүнд: Хөгчүү төрлийн шувуудыг барьж бөгжлөх, сансрын дамжуулагч зүүж нүүдлийн мэдээ цуглуулах, өвөлждөг болон нүүдлийн үедээ бууж амардаг газруудыг тодорхойлох. Бид энэхүү өгүүлэлдээ Чух нуурт 2019-2021 онд хийж гүйцэтгэсэн хөгчүү төрлийн шувуудын нүүдлийн судалгааны үр дүнг нийтэллээ.

Судалгааны материал, арга зүй

Судалгааны талбай

Чух нуур нь Монгол орны зүүн хойд хэсэгт Улаанбаатар хотоос 750 км зайд орших бөгөөд Улз голын сав газарт хамаарагддаг (**1-р зураг**). Тус нуур нь далайн түвшнээс дээш 688 м өндөрт орших бөгөөд баруун болон зүүн талдаа хадан цохио бүхий чулуурхаг эргээр хүрээлүүлсэн, урд хойд хэсгээрээ налуу элсэн хаялга, хайргатай, дугариг хэлбэртэй эрдэст нуур юм. Нуурын гадаргын талбайн хэмжээ 2.1 км², гүн нь 3.5 м эргийн шугамын урт 5.8 км ба баруун урд мөн хойд хэсэгт өтгөн зэгс бүхий бүрдгэй [2].

Материал арга зүй

Бөгжлөх, сансрын дамжуулагч зүүх


Бид хаврын судалгааг 2019, 2020 онд 5 сарын 11-ээс 6-р сарын 10-нд, намрын судалгааг 2019-2021 оны 7 сарын 20-оос 9 сарын 15-ны хооронд хийсэн. Шувуудыг барихдаа нуурын хойд эрэг дагуу гурван метр өргөн, 18 метр урт, хоёр халаастай таван ханан тор байрлуулсан (**1-р зураг**).



1-р зураг. Судалгааны талбай

Торонд баригдсан шувуудаас биометрийн хэмжилтүүдийг авч метал бөгжийг зүүн шилбэнд (*tarsus*), өнгөт бөгжийг (Зүүн-Ази Австрали-Азийн

нүүдлийн замналын сүлжээний эргийн шувууг бөгжлөх удирдамж дээр зааснаар) Монгол орны код болох цэнхэр, ногоон өнгөний дагуу баруун шилбэнд зүүсэн [6] (**2-р зураг**).



2-р зураг. Өнгөт бөгжний хоршил

Бид хөгчүү төрлийн дөрвөн зүйлийн долоон бодгальд Хятадын Hangzhou Yuehai Technology компанийн сансрын дамжуулагчийг шувуудын хондлой хэсэгт (GSM based) зүүсэн (**3-р зураг**) ба тэдгээрээс дөрвөн бодгалийн мэдээллийг судалгааны үр дүнд ашиглалаа. Сансрын дамжуулагчийг зүүхдээ тухайн шувууны биеийн жингийн 3%-иас илүүгүй буюу шувууны биед ямар нэг сөрөг нөлөөгүй байх аргачлалыг баримтлав [7].



3-р зураг. Сансрын дамжуулагч зүүсэн шувууд

Дата анализ

Шувуудын нүүдлийн шилжилт хөдөлгөөн, замнал, урт зэргийг ArcMap 10.8 программ ашиглаж гаргасан. Нүүдлийн үедээ хамгийн багадаа 48 цаг байршсан газрыг нүүдлийн үедээ бууж амардаг газар (НҮБАГ) гэж тодорхойлсон. Шувуудын өдрийн болон нүүдлийн идэвхжилийг тооцоходоо торонд баригдсан шувуудын мэдээг ашигласан. R studio программыг ашиглан шилжилт хөдөлгөөний хэв маягийг тодорхойлохын тулд цэвэр квадрат нүүлгэн шилжүүлэлтийг (NSD, эхлэлийн цэгээс зай) тооцоолж, цаг хугацаа, нүүдлийн эхлэл ба төгсгөл, үргэлжлэх хугацаа, нүүдлийн зам дагуух бууж амардаг газруудын тоог гаргасан.

Судалгааны үр дүн Нүүдлийн идэвхжил


Бид судалгаагаар долоон зүйлийн нийт 277 бодгаль хөгчүү барьж бөгжилсөн. Үүнээс Улаанхөлт хөгчүү 35% (n=97), Шугуйн хөгчүү 30% (n=83), Бүрдний хөгчүү 27.8% (n=77)-ийг эзэлж байгаа ба эдгээр гурван зүйл нь Чух нуур орчимд түгээмэл тохиолдох зүйл юм (1-р хүснэгт).

1-р хүснэгт. Баригдсан бодгалийн тоо, эзлэх хувиар

Зүйл	Бодгалийн тоо	Эзлэх хувь (%)	Хугацаа
Улаанхөлт хөгчүү	97	35	Х/Н
Шугуйн хөгчүү	83	30	Х/Н
Бүрдний хөгчүү	77	27.8	Х/Н
Буурал хөгчүү	8	2.9	Х/Н
Сүүлцагаан хөгчүү	7	2.5	Н
Үхэр хөгчүү	3	1.1	Х/Н
Хар хөгчүү	2	0.7	Х/Н
Нийт	277	100	

*Товчилсон үгийн тайлбар: Х – Хавар, Н – Намар

Хөгчүү төрлийн шувуудын хаврын нүүдлийн оргил үе 2019 онд 5-р сарын 26-30-ны хооронд тохиосон бол 2020 онд 5-р сарын 14-20-ний хооронд байв (4-р зураг).



4-р зураг. Шувуудын хаврын нүүдлийн идэвхжил



5-р зураг. Шувуудын намрын нүүдлийн идэвхжил

Намрын нүүдлийн оргил үе гурван жилийн хугацаанд 8-р сарын 01-ээс 4-ний хооронд тохиосон (5-р зураг) бөгөөд нийт шувуудын 54% (n=239) нь тус хугацаанд баригдсан.

Эдгээр шувуудыг торонд орсон цагаар нь идэвхийг гаргахад 03:00-05:00 болон 20:00-22:00 цагийн хооронд идэвхтэй байна. Нийт шувуудын 46.8% (n=126) нь энэ хугацаанд баригдсан (6-р зураг).



6-р зураг. Шувуудын цагийн идэвхжил

Нүүдлийн замнал ба үргэлжлэх хугацаа

Бид дөрвөн зүйл хөгчүүний долоон бодгальд сансрын дамжуулагч зүүсэн ба дөрвөн бодгалийн мэдээллийг ашигласан. Сансрын дамжуулагч бүхий хөгчүүний нүүдлийн үргэлжлэх хугацааны дундаж нь 26 өдөр (min=5, max=43) байна. Харин нүүдлийн үедээ бодгаль тус бүр хоёр газарт дунджаар 15 хоног (min=14, max=26) амарч байв (2-р хүснэгт).

2-р хүснэгт. Сансрын дамжуулагч зүүсэн шувуудын мэдээлэл

Зүйл	Нийт зай (км)	Нүүдлийн үргэлжлэх хугацаа	НҮБАГ*-н тоо	НҮБАГ*-т байрших хугацаа
Хар хөгчүү	2027.3	16	2	14
Үхэр хөгчүү	2444	43	2	26
Буурал хөгчүү	2069	5	2	10
Улаанхөлт хөгчүү	5845 (дундаж)	33-43	2 (улиралд)	12 (дундаж)

*НҮБАГ- нүүдлийн үедээ бууж амардаг газар

Хар хөгчүү

Хар хөгчүүний бие гүйцсэн бодгалийг 06/08/2019-нд Чух нуураас барьж сансрын дамжуулагчийг зүүсэн. Тус бодгаль намрын нүүдлийн үедээ Яхь нуурт 11 хоног амарсан ба нийт 2027.3 км зам туулан Хятадын Хенан (Henan) мужид хүрч өвөлжсөн боловч 23/05/2020-с хойш дахин мэдээ өгөөгүй (7, 8-р зураг, 3-р хүснэгт).

3-р хүснэгт. Хар хөгчүүний нүүдлийн мэдээ


Байршил	Ирсэн өдөр	Явсан өдөр	Өдөр	Зай (км)	Тайлбар
Чух нуур, Дорнод, Монгол Улс	06/08/2019	-	-	-	Баригдсан газар (НУБАГ)
Яхь нуур, Монгол Улс	09/08/2019	20/08/2019	11	74.3	НУБАГ
Гуши, Шинь Ян, Хенан, Хятад	22/08/2019	23/05/2020	275	1953	Өвөлжсөн газар

*НУБАГ- нүүдлийн үедээ бууж амардаг газар



7-р зураг. Хар хөгчүүний нүүдлийн замнал

Spotted Redshank



8-р зураг. Дамжуулагчтай Хар хөгчүүний эхлэх цэгээс холдох зай (NSD).

Үхэр хөгчүү

Үхэр хөгчүүний бие гүйцсэн бодгалийг намрын нүүдлийн үед буюу 25/07/2019-нд барьж дамжуулагч зүүсэн. Тус бодгаль Чух нуураас 2444 км зам туулж Хятадын Хунаньд (Hunan) хүрсэн ба нүүдлийн үедээ Шар тэнгисийн орчимд хоёр хоносон. Тус газраа хоёр хоносны дараа дахин нисэж 1074 км замыг туулан Хятадын Хунаньд (Hunan) хүрч 17 өдрийн турш тухайн газраа байршсан ба 09/09/2019-с хойш дахин мэдээ өгөөгүй (**9, 10-р зураг, 4-р хүснэгт**).

4-р хүснэгт. Үхэр хөгчүүний нүүдлийн мэдээ


Байршил	Ирсэн өдөр	Явсан өдөр	Өдөр	Зай (км)	Тайлбар
Чух нуур, Дорнод, Монгол Улс	25/07/2019	18/08/2019	24	-	Баригдсан газар (НУБАГ)
Лай Жоу Вань, Дун Ин, Шан Дун, Хятад	21/08/2019	23/08/2019	2	1370	НУБАГ
Нан Шиань, И Ян Ши, Хунань, Хятад	23/08/2019	09/09/2019	17	1074.4	Мэдээ тасарсан

*НУБАГ- нүүдлийн үедээ бууж амардаг газар



9-р зураг. Үхэр хөгчүүний нүүдлийн замнал

Common Greenshank



10-р зураг. Дамжуулагчтай Үхэр хөгчүүний эхлэх цэгээс холдох зай (NSD)

Буурал хөгчүү

Бид 06/06/2019-нд буюу хаврын нүүдлийн үед нь Буурал хөгчүүний бие гүйцсэн бодгальд дамжуулагч зүүсэн. Дамжуулагч зүүснээс найман өдрийн дараа Оросын Арахлей (Arakhley) нууранд бүртгэгдсэн бөгөөд нийтдээ 54 өдрийн турш мэдээ өгөөгүй.

Үүний дараа Хятадын Жоу Зи (Zhouzi) мужид бүртгэгдсэн ба 2 хоносон байв. Үүний дараагаар


08/08/2019-нд Шар тэнгисийн хойд эрэг болох Бохай Ван (Bohai Wan) орчим 3 өдрийн турш байсан бөгөөд 11/08/2019-с хойш мэдээ өгөөгүй (**11,12-р зураг, 5-р хүснэгт**).

5-р хүснэгт. Буурал хөгчүүний нүүдлийн мэдээ

Байршил	Ирсэн өдөр	Явсан өдөр	Өдөр	Зай (км)	Тайлбар
Чух нуур, Дорнод, Монгол Улс	06/06/2019	14/06/2019	8	-	Баригдсан газар (НУБАГ)
Арахлей нуур, ОХУ	16/06/2019	-	-	320.7	Мэдээ тасарсан
Жоузи Шиань, Вуланьчабу, Өвөр Монгол, Хятад	06/08/2019	08/08/2019	2	1246	Мэдээ өгөөгүй
Бохай Ван, Бинь Хай Тиань Жинь, Хятад	08/08/2019	11/08/2019	3	502.4	Мэдээ тасарсан



11-р зураг. Буурал хөгчүүний нүүдлийн замнал



12-р зураг. Дамжуулагчтай Буурал хөгчүүний эхлэх цэгээс холдох зай (NSD)

Улаанхөлт хөгчүү

Бид 25/07/2019-ны өдөр Чух нуураас бие гүйцсэн Улаанхөлт хөгчүүнд сансрын дамжуулагчийг зүүсэн. Тус бодгаль намрын нүүдэлдээ 5690 км, хаврын нүүдэлдээ 6000 км орчим замыг туулсан. Хавар Индонезийн Шуань дай Бей (Xuan Dai Bay), Хятадын Хэбэй (Hebei) мужийн Тан Шан (Tangshan), намар Хятадын Гуанши (Guangxi) мужийн Тиз Шань Ган (Tieshan Gang) болон Малайзын Саравак (Sarawak) мужийн Бинтулу (Bintulu) зэрэг нутгуудад бууж амарсан. Тус бодгаль Индонезийн Төв Калимантан (Central Kalimantan) мужийн Бангкал (Bangkal) хотын ойролцоо 2019, 2020 онуудад өвөлжсөн (**13, 14-р зураг, 6-р хүснэгт**).


6-р хүснэгт. Улаанхөлт хөгчүүний нүүдлийн мэдээ

Байршил	Ирсэн өдөр	Явсан өдөр	Өдөр	Тайлбар
Чух нуур, Дорнод, Монгол Улс	25/07/2019	22/08/2019	28	Баригдсан газар
Чух, нуур – Улз гол, Дорнод, Монгол	16/05/2020	29/07/2020	74	Үрждэг газар
Тиз Шань Ган, Бэй Хай, Гуанши, Хятад	28/08/2019 31/07/2020	15/09/2019 24/08/2020	18 24	НУБАГ
Бинтулу, Саравак, Малайз	17/09/2019 29/08/2020	23/09/2019 09/09/2020	6 11	НУБАГ
Бангкал, Төв Калимантан, Индонез	24/09/2019 10/09/2020	03/04/2020 06/02/2021	192 149	Өвөлжсөн газар
Шуань дай Бей, Индонез	04/04/2020	04/11/2020	7	НУБАГ
Нин Бин муж, Вьетнам	04/15/2020	-	-	Мэдээ өгөөгүй
Тан Шань, Хэбэй, Хятад	09/05/2020	14/05/2020	5	НУБАГ

*НУБАГ- нүүдлийн үедээ бууж амардаг газар



13-р зураг. Улаанхөлт хөгчүүний нүүдлийн замнал



14-р зураг. Дамжуулагчтай Улаанхөлт хөгчүүний эхлэх цэгээс холдох зай (NSD)

Бөгжилсөн шувуудын дахин ажиглалтын мэдээ

Чух нуурт бөгжилсөн Улаанхөлт хөгчүүний нийт долоон бодгаль, Бүрдний хөгчүүний нэг бодгаль Зүүн-Азийн орнуудад дахин ажиглагдсан тухай мэдээллийг тус бүс нутгийн судлаачид бидэнд ирүүлсэн (7-р хүснэгт). Тус шувуудын дахин ажиглагдсан байршлыг 15-р зурагт харуулав.

7-р хүснэгт. Бөгжилсөн шувуудын дахин ажиглалтын мэдээ

Зүйл	Огноо	Байршил
Бүрдний хөгчүү	28/09/2019	Жианганжень, Дун Тай, Янчэн. Жиансу, Хятад
Улаанхөлт хөгчүү	17/03/2020	Футиань, Байгалийн нөөц газар, Шэньжэнь, Хятад
	25/03/2020	Шэньжэнь, Хятад
	28/04/2020	Футиань, Байгалийн нөөц газар, Шэньжэнь, Хятад
	07/08/2020	Кучинг, Саравак, Малайз
	02/09/2020	Кучинг, Саравак, Малайз
	27/10/2020	Май По Байгалийн нөөц газар, Хон Конг Хятад
	07/11/2021	Май По Байгалийн нөөц газар, Хон Конг Хятад



15-р зураг. Шувуудын дахин ажиглагдсан байршил

Хэлэлцүүлэг

Идэвхжил: Хөгчүү төрлийн шувуудын хаврын нүүдлийн идэвхжилийн оргил үе нь эхний жил 5 сарын сүүлийн долоо хоногт байсан бол хоёр дахь жилд 5 сарын дунд орчимд тохиож байв. Шувуудын хаврын идэвхжил нь тухайн жилийн цаг агаарын аливаа нэг хүчин зүйлсээс хамаардаг талаар судлаачид дурдсан байдаг [18] ба Чух нуурын хаврын судалгааны хувьд цаг агаарын хүчин зүйлс нөлөөлсөн байж болох юм. Учир нь ОХУ-ын судлаачид Шугуйн хөгчүүний хаврын нүүдэл хангалттай дулаан цаг агаар тогтсон үед буюу өдрийн дундаж агаарын температур 0 хэмийг давсны дараа эхэлдэг бөгөөд энэ үед Байгаль нуур руу цутгаж буй Сэлэнгэ мөрний цутгал хөндийгөөр шувуудын нүүдэл хамгийн эрчимтэй байдаг гэжээ. Энэ баримтыг Байгаль нуурын бүс нутаг дахь шувуудын нүүдлийн судалгаанд оролцсон дийлэнх судлаачид тэмдэглэсэн хэмээн бүтээлдээ дурджээ [8]. Мөн тус зүйл шувуу хаврын нүүдлийн үедээ газар дундын тэнгисийг даван хойд зүг рүү нүүдэллэхэд шувуудын биеийн жин нэмэгддэг байна [9]. Камчатка болон Магадан, Сахалин муж, Хабаровск зэрэг Оросын Охотскийн тэнгисийн орчмын Шугуйн хөгчүүний хаврын нүүдэл 4 сарын дунд үеэс 6-р сарын эхэн үе хүртэл үргэлжилдэг бол намрын нүүдэл нь 7-р сарын эхэн үеэс 10-р сарын дунд үе хүртэл үргэлжилдэг байна [10]. Чух нуур бол зарим зүйл хөгчүүний хувьд үржлийн нутаг юм [2]. Иймд хаврын нүүдлийн идэвхжилийн хоёр жилийн өөрчлөлтөд дайран өнгөрдөг нүүдлийн шувуудаас гадна энэ орчимд үрждэг шувуудын идэвхжил нөлөөлсөн байх боломжтой. Учир нь үржлийн шувуу болох Улаанхөлт хөгчүү, Бүрдний хөгчүү зэрэг шувууд хаврын нүүдлийн хугацаанд өдөр бүр тогтмол баригдаж байв. Харин судалгааны гурван жилийн хугацаанд намрын нүүдлийн идэвхжил

нь жил бүр 8 дугаар сарын эхний 7 хоногт тогтмол тохиосон. Өөрөөр хэлбэл Чух нуураар дайран өнгөрөх шувуудын намрын нүүдлийн хугацаа харьцангуй тогтвортой байв. Өмнөд Беларусийн Шугуйн хөгчүүний намрын нүүдэл 6-р сарын дунд үеэс эхэлдэг бөгөөд намрын нүүдлийн сүүлч нь 10-р сарын эхэн үе хүртэл үргэлжилдэг байна [11]. Улаанхөлт хөгчүүний дэд зүйл болох *ussuriensis*-ийн намрын нүүдэл 8-р сарын 10-аас хойш хамгийн нягтшил өндөртэй (20-60 бодгаль/км²) тохиолддог байна [12]. Камчаткийн баруун хэсэгт тохиолдох Хар хөгчүүний хувьд намрын нүүдэл 7 сарын дунд үеэс эхэлж 9 сарын дунд үед дуусдаг бөгөөд ихэнх шувууд урт замыг туулсны дараагаар амардаг ба цаг агаар ширүүн салхитай үед нүүдлээ түр зогсоодог гэдгийг судлаачид бүтээлдээ дурджээ [13]. Цагийн идэвхжилийн хувьд өглөө 03:00-05:00 цагийн хооронд болон орой 20:00-22:00 цагийн хооронд хамгийн идэвхтэй байсан. Дийлэнх шувууд зан төрхийн хувьд шөнөөр нүүдэллэх хандлагатай байдаг ба үүнийг нь тэдний махчин шувуудаас зайлсхийх зан төрх гэж судлаачид үздэг байна [14]. Шувууд нүүдлийн үедээ тодорхой хэмжээнд бууж амардаг хэд хэдэн газартай ба тэндээ өдрийн цагаар амарч ихэвчлэн идэвхтэй хооллодог онцлогтой [15].

Нүүдлийн замнал: Хар хөгчүү. Чух нуураас дамжуулагчтай ниссэн Хар хөгчүү намрын нүүдлийн үедээ Яхь нуурт 11 хоног амарсан. Тухайн нуур Хар хөгчүүний хувьд намрын нүүдлийн үедээ амардаг газруудын нэг болж байна. Үүний дараа тус бодгаль 1800 км орчим замыг нэг хоногийн хугацаанд туулж Хятадын Хенан (Henan) мужид хүрч тэндээ өвөлжсөн боловч түүнээс хойш дахин мэдээ өгөөгүй. Хэдий тийм боловч энэ бүс нутаг нь тархцын хувьд Хар хөгчүүний өвөлждөг нутаг гэжээ [3]. Тус хөгчүүг бид намрын нүүдлийн үед нь Чух нуураас барьсан учир хаврын нүүдлийн мэдээг авч чадаагүй. Гэсэн ч Хар хөгчүүг арктикийн бүс нутагт үрждэг гэдгийг судлаачид бүтээлдээ дурдсан байдаг [14].

Үхэр хөгчүүний үржлийн нутаг нь Сибир ба өвөлждөг нутаг нь өмнөд Африк, Энэтхэг, Тайланд мөн Хятадын өмнөд хэсэг юм [17]. Дамжуулагчтай Үхэр хөгчүү нүүдлийн үедээ Шар тэнгисийн орчимд хоёр хоносон нь тухайн газар нүүдлийн үедээ бууж амардаг газар болохыг илтгэж байна. Тус газраа хоёр хоносны дараа дахин нисэж 1074 км замыг туулан Хятадын Хунаньд (Hunan) хүрч 17 өдрийн турш тухайн газраа байршсан ба үүнээс хойш мэдээ өгөөгүй. Энэ бүс нутгийг энэ зүйл хөгчүүний

өвөлждөг нутаг гэж үзэж байна. Учир нь тухайн бүс нутаг Үхэр хөгчүүний өвөлждөг бүс нутагт хамаарагддаг [3].

Буурал хөгчүүний хаврын нүүдлийн үедээ амардаг газруудын Чух нуур гэж үзэж байна. Учир нь Буурал хөгчүү дамжуулагч зүүснээс хойш Чух нуурт нийтдээ найман өдрийн турш байршсан. Үүний дараа Чух нуураас хойд зүгт 320,7 км нисэж Оросын Арахлей (Arakhley) нууранд хүрээд дамжуулагчийн мэдээ тасарсан бид тус нуурыг үржлийн нутаг нь гэж дүгнэж байна. Учир нь Буурал хөгчүүний үржлийн тархац энэ нутагт хамаарагддаг байна [14]. Харин 8-р сарын 6-нд Хятадын Жоу Зи (Zhouzi) мужийн ойролцоо мэдээ өгч эхлээд тус газарт хоёр хоносон байв. Үүний дараагаар Шар тэнгисийн хойд эрэг болох Бохай Ван (Bohai Wan) орчим гурван өдрийн турш байсан ба үүнээс хойш мэдээ өгөөгүй байна. Буурал хөгчүүний дэлхийн популяцийн 90% нь Австралид өвөлждөг [17]. Иймд бид Бохай Ванг (Bohai Wan) Буурал хөгчүүний намрын нүүдлийн үедээ амардаг газруудын нэг гэж тодорхойлж байна.

Улаанхөлт хөгчүү. Бидний дамжуулагч зүүсэн Улаанхөлт хөгчүү хавар, намрын нүүдлийн үедээ тус бүр хоёр удаа бууж амарсан. Хавар Индонезийн Шуань дай Бей (Xuan Dai Bay), Хятадын Хэбэй (Hebei) мужийн Тан Шан (Tangshan), намар Хятадын Гуанши (Guangxi) мужийн Тиэ Шань Ган (Tieshan Gang) болон Малайзын Саравак (Sarawak) мужийн Бинтулу (Bintulu) зэрэг нутгуудыг нүүдлийн үедээ амардаг газар болгон ашиглалаа. Нүүдлийн стратегийг нь үзэхэд Улаанхөлт хөгчүү нь намар цөөн тооны газарт урт хугацаанд амарч буй бол хаврын нүүдэлд олон газарт богино хугацаанд зогсолт хийж нүүдэллэдэг байна [19]. Хоёр намрын нүүдлийн хувьд зогсолт хийсэн газрууд ижил боловч хугацааны хувьд адилгүй байна. Энэ бодгаль хоёр жил дараалан Индонезийн Төв Калимантан (Central Kalimantan) мужийн Банггал (Bangkal) орчим тариан талбай бүхий газар очиж өвөлжсөн. Мөн Чух нуурт бөгжилсөн зарим Улаанхөлт хөгчүү Хонг Конгийн Май По (Mai Po) байгалийн нөөц газарт өвөлждөг [2].

Бүрдний хөгчүү Чух нуурын урд, хойд бүрдэд үржлийн тохиолдох зүйл юм [2]. Сансрын дамжуулагч зүүгээгүй учир өвөлждөг нутаг, нүүдлийн үедээ амардаг газрыг тогтоож чадаагүй. Хэдий тийм ч бөгжний давтан ажиглалтын мэдээгээр тус зүйл хөгчүү Хятадын Жиан Су (Jiangsu) мужид өвөлжиж буй нь батлагдсан [2].

Шугуйн хөгчүү Чух нуурт хавар, намрын улиралд цөөн тоогоор бүртгэгддэг, нүүдлийн үедээ

дайран өнгөрдөг, түгээмэл тохиолдох зүйл юм [2]. Сансрын дамжуулагч зүүж чадаагүй учир нүүдлийн үедээ амардаг газар, үрждэг мөн өвөлждөг нутгийг тодорхойлох боломжгүй байсан.

Сүүлцагаан хөгчүү нь Чух нуурт намрын улиралд ховор бүртгэгддэг цөөн тоотой тогтмол тохиолдох зүйл юм [2]. Ялангуяа энэ зүйл хөгчүү нь нуур гэхээс илүү голын хөндий, хээрээр байх жижиг тогтоол ус бараадан нүүдлийн үедээ түлхүү ажиглагддаг. Энэ зүйлийн хувьд сансрын дамжуулагч зүүгээгүй учир үрждэг болон өвөлждөг газар, нүүдэлдээ бууж амардаг газрыг тодорхойлох боломжгүй байв.

Дүгнэлт

1. Чух нуураар дайран нүүдэллэж буй хөгчүү төрлийн шувуудын хаврын нүүдлийн хугацаа тогтворгүй бол намрын нүүдлийн хугацаа харьцангуй тогтвортой байна.
2. Нүүдлийн идэвхийн тухайд хөгчүүний нүүдэл бүхэл өдөржин идэвхтэй байдаг ч өглөө, орой бүрэнхий үед хамгийн өндөр байна.
3. Бид сансрын дамжуулагч зүүсэн 4 зүйл хөгчүүний нүүдлийн замнал, бууж амардаг болон үрждэг, өвөлждөг газруудыг тодорхойлсон бөгөөд өнгөт бөгжний давтан ажиглалтын мэдээгээр Бүрдний хөгчүүний өвөлждөг нутгийг тодорхойллоо.

Талархал

Энэхүү судалгааны ажилд оролцох боломжийг олгож, тусалж дэмжсэн удирдагч багш доктор Г.Онолрагчаа, Монголын шувуу хамгаалах төвийн харьяа Чух шувуу судлалын суурингийн хамт олон, шувуу барих зөвшөөрлийг олгосон БОАЖЯ, Шувуудын дахин ажиглалтын мэдээ илгээсэн Хятад, Тайланд, Хонконгийн шувуу судлаач, ажиглагч нар, ялангуяа Хонконгийн шувуу ажиглагчдын нийгэмлэгийн эргийн шувуу судлаач Katherine Leung, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Биологийн тэнхимийн эрдэмтэн багш нар, Зүүн бүсийн Дархан цаазат газруудын “Дорнод” хамгаалалтын захиргааны хамт олон, Hangzhou Yuehai Technology компанийн ажилтан Fang Bingxiang болон нийт судалгаанд оролцсон оюутнууд, Дашбалбар сумын малчин Д.Дашдорж түүний гэр бүлд талархал илэрхийлье

Энэхүү судалгааг БОАЖЯ-ны олгосон шувуу барих 2019 оны 04 сарын 22-ны 06/2565, 2020 оны 05 сарын 07-ний 06/3245, 2021 оны 07 сарын 23-ны 03/3268 тоот зөвшөөрлийн дагуу гүйцэтгэлээ.

Санал, зөвлөмж

1. Сансрын дамжуулагч зүүж чадаагүй зүйлүүд болох Бүрдний хөгчүү, Сүүлцагаан хөгчүү, Шугуйн хөгчүүнд сансрын дамжуулагч зүүж тэдний нүүдлийг замналыг тандан судлах шаардлагатай байна.
2. Хар хөгчүүний намрын нүүдлийн амардаг газар болох Яхь нуурын эргийн шувуудын тоо толгойд нүүдлийн улирлаар ажиглалт хийх.
3. Хаврын судалгааг 4 сарын эхэн үед эхэлж нүүдлийн идэвхжилийг бүтэн тодорхойлох буюу хавар идэвхжих хугацаа нь цаг агаараас хамаарч байгаа эсэхийг анхаарч үзэх.
4. Өнгөт бөгжний арга бол нүүдлийн замнал, үрждэг болон өвөлждөг газруудыг тогтооход хамгийн хямд арга учир цаашид давтан ажиглалтын мэдээг сайтар цуглуулахад анхаарах хэрэгтэй.
5. Зүүн өмнөд азийн орнуудын шувуу судлалын байгууллагуудтай эргийн шувуу бөгжлөх мониторингийн судалгаанд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллийг солилцох сүлжээг сайжруулах шаардлагатай байна.

Ашигласан бүтээл

- [1] Conklin, J. R., Verkuil, Y. I., & Smith, B. R., “Prioritizing migratory shorebirds for conservation action on the East Asian-Australasian Flyway,” p. 132, 2014.
- [2] Mongolian Bird Conservation Center, “Chukh Bird Research Station Annual Reports 2019-2022”.
- [3] BirdLife International, IUCN Red List for birds. [Online]. Available: <http://datazone.birdlife.org>
- [4] Ганхуяг.П ба Амархүү.Г, Дорнод аймгийн шувууд, vol 1. Улаанбаатар, Монгол Улс, 2022.
- [5] Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch., Mongolian Red List of Birds, vol. 7. Ulaanbaatar, Mongolia, 2011.
- [6] EAAFP, “Shorebird Color Flagging Protocol on the East Asian-Australasian Flyway,” 2015.
- [7] Murray, D. L., & Fuller, M. R., A critical review of the effects of marking on the biology of vertebrates. Research techniques in animal ecology: controversies and consequences. 2000.
- [8] Melnikov Yu. I, “Migration of *Tringa glareola* in the Baikal region,” Russian Ornithological Journal, vol. 248, pp. 1443–1450, 2003. (Russian).
- [9] Y. Muraoka, C. H. Schulze, M. Pavličev, and G.

- Wichmann, “Spring migration dynamics and sex-specific patterns in stopover strategy in the Wood Sandpiper *Tringa glareola*,” *J Ornithol*, vol. 150, no. 2, pp. 313–319, Apr. 2009, <https://doi.org/10.1007/s10336-008-0351-5>
- [10] Tuinov I.M and Gerasimov Yu.N., “Seasonal migration of *Tringa glareola* in the Sea of Okhotsk region,” *The biology and conservation of the birds of Kamchatka*, vol. 13, pp. 33-46., 2021, (Russian). https://doi.org/10.53657/9785936991097_33
- [11] Pinchuk P.V., “Autumn migration of the Wood Sandpiper (*Tringa glareola*) in the Southern Belarus (Pripyat FloodPlain),” vol. 6, 2003.
- [12] Glushchenko Yu.N. *et al.*, “Materials of study of the *Tringa totanus ussuriensis* in the Russian Far East,” *Russian Ornithological Journal*, vol. 32, pp. 331–338, 2023, (Russian).
- [13] Tiunov I.M. and Gerasimov Yu.N., “The *Tringa erythropus* in the Sea of Okhotsk region, The biology and conservation of the birds of Kamchatka, vol. 12, pp. 77–83, 2019 (Russian).
- [14] Cramp, S., Simmons, K. L. E., Brooks, D. C., Collar, N. J., Dunn, E., Gillmor, R., & Wilson, M. G., *Handbook of the birds of Europe, the Middle East and North Africa. The birds of the Western Palearctic*, vol. 3. in *Waders to gulls*. 1983.
- [15] Remisiewicz, M., Tree, A. J., Underhill, L. G., & Nowakowski, J. K., “Geographical patterns in primary moult and body mass of Greenshank *Tringa nebularia* in southern Africa. *Ardea*,” pp. 31–46, 2014. <https://doi.org/10.5253/078.102.0109>
- [16] Hoyo, J, *Handbook of the birds of the world.*, vol. 1. in *Ostrich to Ducks*. Lynx Edicions, vol. 1. 1996.
- [17] Bamford, M., Watkins, D., Bancroft, W., Tischler, G., & Wahl, J., “Migratory shorebirds of the East Asian-Australasian flyway: Population estimates and internationally important sites Canberra: Wetlands International, Oceania,” p. 237, 2008.
- [18] Lameris, T. K., Scholten, I., Bauer, S., Cobben, M. M., Ens, B. J., & Nolet, B. A., “Potential for an Arctic-breeding migratory bird to adjust spring migration phenology to Arctic amplification,” *Global Change Biology*, 2017, <https://doi.org/10.1111/gcb.13684>
- [19] D. Li *et al.*, “Shorebirds wintering in Southeast Asia demonstrate trans-Himalayan flights,” *Sci Rep*, vol. 10, no. 1, p. 21232, Dec. 2020, <https://doi.org/10.1038/s41598-020-77897-z>